http://www.breakingnews.mn/c/r/27712

# Ж.Лангтри: Австралийн элчин сайдын яам олон чиглэлээр ажиллана

125 Өчигдөр 17:45




*Австралийн Холбооны Улс манай улсад элчин сайдын яам албан ёсоор энэ сарын 30-нд нээлтээ хийлээ. Энэ арга хэмжээний үеэр Австрали-Монгол хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны талаар түүхэн үйл явдал, баримтуудыг үзүүлж, танилцуулав.*

*Дараа нь Австралийн Холбооны Улсаас Монгол Улсад суугаа анхны Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ж.Лангтригаас тодруулга авлаа.*

**-Монголд Австралийн Холбооны Улсын элчин сайдын яам нээлтээ хийж байгаад баяр хүргэе. Цаашид хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа ямар түвшинд хүрнэ гэж үзэж байна вэ?**

-Элчин сайдын яам нээнэ гэдэг хоёр орны хүмүүсийн санаа бодлыг илүү ойр дотно болгох явдал байдаг юм. Хамгийн эхлээд бид хоорондоо холбогдох, дараа нь хамтран ажиллах, тэгээд амжилтад хүрэх гэсэн зарчмаар ажиллана. Стратегийн хувьд бид Монгол Улсын сонгосон ардчилал, чөлөөт зах зээлийг замыг хүндэтгэж байгаа.

**-Манай улс Австрали Улстай уул уурхай, боловсролын салбарт илүү ойр харилцаатай. Цаашид аль салбарт хамтран ажиллах боломжтой вэ?**

-Том хөрөнгө оруулалтыг дэмжих нь хоёр орны Засгийн газарт чухал асуудлын нэг гэж би бодож байна. Үндэсний хэмжээний болон тухайн бүс нутаг, орон нутагт хөрөнгө оруулагчдыг оруулж, дэмжих нь илүү ач холбогдолтой юм. Австралийн Засгийн газар ч ийм хүсэлтэй байгаа. Ялангуяа боловсролын салбар цаашид улам өргөжихөд маш сайн суурь Монголд бий. Элчин сайдын яамны хувьд цаашид соёл, спортын салбарт анхаарч ажиллах болно. Монголд анх удаа манай улсын элчин яам шинээр байгуулагдаж байгаа учир бидэнд зохион байгуулалтын ажил их байна. Мөн энэ оны зуны сарын сүүлээр элчин сайдын яам өөрийн байртай болно гэдэгт найдаж байна. Элчин сайдын яамны ажил цэгцэрсний дараа маш олон чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлнэ.

**Ярилцсан Б.Баярмаа**

**Эх сурвалж: www.breakingnews.mn**

**John Langtry: Australian Embassy will work in many directions**
**Yesterday: 17:45PM**

The Australian Embassy has held its opening ceremony on the 30th of this month. During the event, facts and historical events have been demonstrated to present the relationship and collaboration between Australia and Mongolia.

After the event, the Extraordinary and Plenipotentiary Ambassador, John Langtry responded to our questions:

- **Congratulations on the opening of the Embassy in Mongolia. How do you foresee the future bilateral relationships and collaboration between our two countries?**
- Opening an Embassy means that it would make the minds of people in our two countries more close together. First, we will be connected, then collaboration will be followed, finally we will succeed in achievements. Strategically, we respect democracy and free market system that Mongolia has chosen.
- **Our country has more close collaboration with Australia in mining and education sectors. In the future, in which areas the will the Embassy be more involved in?**
- I think supporting bigger investments is one of the important issues for both governments. It is important to support and invite investors at the local, regional and national levels. The Australian government has this on the agenda. Particularly, there are opportunities for development in Mongolian education sector. Since our Embassy is new to Mongolia, we need enormous organizational details. At the end of this summer, we hope to have our own building. After settling down the Embassy, we will start expanding our relationship in many different areas.

**Interviewed by: B. Bayarmaa**
**www.breakingnews.mn**